



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/28

Мандалговь

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1"б", 29.1.3."б", 29.1.4."а", 29.1.5."а", Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалт, Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Гурвансайхан сумын Салхитын мөнгөний орд дээр ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч "Эрдэнэс силвер ресурс" ХХК-тай 2020 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр байгуулсан №01/2020 тоот "Хамтран ажиллах гэрээ"-ний 2.7 –д заасан орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн "Дундговь хөгжинө баялгийн сан" (Хөгжлийг дэмжих сан)-г бие даасан хуулийн этгээдийн хэлбэрээр үүсгэн байгуулж, ажиллуулах санал боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Дарга:	М.Анхбаяр	(Аймгийн Засаг даргын орлогч)
Нарийн бичгийн дарга:	П.Очирбат	(Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)
Гишүүд:	Л.Доржбат	(Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга)
	Н.Эрдэнэ-Очир	(Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга)
	Г.Энхтайван	(Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга)
	Б.Түвшинбаяр	(Хууль эрх зүйн хэлтсийн дарга)
	Ш.Төрбат	(Мэргэжлийн хяналтын газрын дарга)
	М.Болор-Эрдэнэ	(Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Хоёр. Хөгжлийг дэмжих санг байгуулж, ажиллуулах саналыг 2021 оны 1-р улиралд багтаан боловсруулж, Засаг даргын зөвлөлд танилцуулахыг ажлын хэсэг (М.Анхбаяр)-т үүрэг болгосугай.

Гурав. Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны 04 сарын 06-ны өдрийн А/89 тоот Ажлын хэсэг томилох тухай захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481213060